



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 10

Мөрөн

**Орон нутгийн өмчит компани  
үүсгэн байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, Иргэний хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XII хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. “Хөдөөгийн Шийдэл” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн байгуулсугай.

2. “Хөдөөгийн Шийдэл” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Компанийн баримт бичгийг бүрдүүлж Улсын бүртгэлд бүртгүүлэх үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.МӨНГӨНХУЯГ



119120092

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2022 оны 07 дугаар сарын  
27 ны өдрийн ээлжит XII хуралдааны  
...10 дугаар тогтоолын хавсралт

“ХӨДӨӨГИЙН ШИЙДЭЛ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ  
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

НЭГ:НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.“Хөдөөгийн-Шийдэл” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани нь түрээсийн орлого болон өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж, бие даан хуулийн этгээдийн харилцаанд ордог ашгийн төлөөх хязгаарлагдмал хариуцлагатай компани мөн.

1.2.“Хөдөөгийн-Шийдэл” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “Компани” гэх) нь Монгол улсын “Иргэний хууль”, “Төсвийн тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Компанийн тухай хууль”, “Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам” болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн дагуу “Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани” хэлбэрээр ажиллана.

1.3.Энэхүү дүрмийн зорилго нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналт, компанийн эд хөрөнгийн эрх, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх зэрэгтэй холбогдох үйл ажиллагааны харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.4.“Хөдөөгийн-Шийдэл” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн өмчлөгч нь иргэдээ төлөөлөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (цаашид “аймгийн ИТХ” гэх) байна.

1.5.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь өмчлөгч болохын хувьд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллана.

1.6.Аймгийн Засаг дарга нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн өмчийн эд хөрөнгийн талаар гаргасан шийдвэрийг Засгийн газрын бодлогод нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

ХОЁР: ОНООСОН НЭР, ОРШИН БАЙГАА ГАЗАР

2.1.Оноосон бүрэн нэр нь “Хөдөөгийн Шийдэл” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байх ба товчилсон нэр нь “Хөдөөгийн-Шийдэл” ХХК байна.

2.2. Үйлдвэрийн газрын оршин байгаа газар нь: Хөвсгөл аймаг, Мөрөн сум 7-р баг

2.3. Үйлдвэрийн газрын шуудангийн хаяг: Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 7-р баг

2.4. Үйлдвэрийн газрын цахим шуудангийн хаяг: [huduugiinshidel@gmail.com](mailto:huduugiinshidel@gmail.com)

ГУРАВ:ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН БЭЛГЭДЭЛ, ТЭМДЭГ



3.1. “Хөдөөгийн-Шийдэл” ХХК нь өөрийн бэлгэдэл тэмдэгтэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

3.2. Бэлэгдэл, тэмдгийн загварыг “Хөдөөгийн Шийдэл” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ баталж, Улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд түүний хэрэглэх эрхийг компани эдэлнэ.

3.3. Тэмдгээр үйлдвэрийн газрын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.

3.4. Тэмдгийг компанийн газрын захирал болон захирлаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, ашиглалт, хадгалалт, хамгаалтыг хариуцна.

#### ДӨРӨВ: “ХӨДӨӨГИЙН ШИЙДЭЛ” ХХК-ИЙН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХУГАЦАА

4.1. “Хөдөөгийн-Шийдэл” ХХК нь хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл, бизнесийг байгалийн эрс тэс нөхцөлд зохицсон, орчин үеийн дэвшилтэт техник, хэрэгслийг нэвтрүүлэх, шинжлэх ухааны ололттой технологийг нутагшуулах, нэгжээс авах үр ашгийг нэмэгдүүлж эрүүл хүнс, чанартай бараа бүтээгдэхүүнийг орон нутагтаа үйлдвэрлэх зорилготой иргэд, аж ахуйн нэгжийг чадавхжуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүү, хөрөнгийн хямд эх үүсвэрээр дэмжихэд оршино.

4.1.1. Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн шилмэл үүлдрийн мал амьтан, үр бордоо, багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн түрээсийн үйл ажиллагаа

4.1.2. Хөвсгөл аймгийн цаг агаар, байгалийн нөхцөлд тохирох мал амьтан үржүүлэх, үр сорт нутагшуулан таримал сонирхолтой иргэд байгууллагыг сургаж дадлагажуулах, технологи дамжуулах, үйл ажиллагааг дэмжих

4.1.3. Иргэд хоршиж үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, аж ахуйн нэгж байгуулах, санхүү төсвөө удирдах үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж сургалт хийх

4.1.4. Хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээх болон бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх, бордох, бэлчээрийг усжуулах, тарималжуулах иргэд аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх

4.1.5. Хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, хадгалах, стандартын шаардлага хангасан агуулах, зорь, өвөл зуны хүлэмж барих үйл ажиллагаанд бага хүүтэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх

4.1.6. Батлагдсан үүлдэр, омгийн малаар цөм сүргийг бүрдүүлж хамгаалах, үржүүлэх, өндөр ашиг шимт малыг нутагшуулах, цөм сүргээс малчдад стандартын шаардлага хангасан хээлтэгч хээлтүүлэгчийг түрээслэх, худалдан борлуулах, ашиг шимийн төрөлжсөн мал аж ахуйн цогцолбороор бий болгох ажлыг зохин байгуулах

4.1.7. Хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх

4.1.8. “Хөдөөгийн-Шийдэл” ХХК нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулахад холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлснээр тухайн үйл ажиллагааг эхэлнэ.

4.1.9. “Хөдөөгийн-Шийдэл” ХХК-ын дүрэмд орсон өөрчлөлтүүдийг хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

4.1.10. Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр “Хөдөөгийн шийдэл” ХХК-ийг хувьчлах, өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд үйлдвэрийн газар нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

## ТАВ: “ХӨДӨӨГИЙН ШИЙДЭЛ” ХХК-ИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ

5.1.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанаас бүрдэх бөгөөд компанийн энэхүү зарласан хувьцааны нэг бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 161 000 ширхэг энгийн хувьцаатай байна.

5.1.2. Компани нь хувьцаа гаргаж болох бөгөөд гаргах хувьцааны төрөл, тоо, нэрлэсэн үнийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн санал болгосноор Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

5.1.3. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу бусад үнэт цаас гаргаж болно.

5.1.4. Компанийн хувьцаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй болно.

5.1.5. Компанийн хөрөнгө нь 1 00 хувь Хөвсгөл аймгийн өмчид байгааг харгалзан компанийн хувьцаа нь Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр гарах хүртэл арилжаалагдахгүй байна.

5.1.6. Эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй байна:

5.1.6.1. Өөрт олгогдсон үл хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглах, хадгалж хамгаалах, түрээслүүлэх

5.1.6.2. Үндсэн хөрөнгийг аймгийн ИТХ, ТУЗ-ийн хурлаас олгосон эрх хэмжээний дотор захиран зарцуулах;

5.1.6.3. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан эсвэл бусдаар гэрээгээр борлуулах

5.1.6.4. “Хөдөөгийн шийдэл” ХХК-ны үндсэн хөрөнгийг зөвхөн ТУЗ-ийн хурлын санал, Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлөөр Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн акталж данснаас хасах, худалдан борлуулах, устгах, шилжүүлэх эрхтэй;

## ЗУРГАА. КОМПАНИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6.1. “Хөдөөгийн шийдэл” ХХК-ны удирдлага нь дараах бүтэцтэй байна:

6.1.1. Өмчлөгч /аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал/

6.1.2. Төлөөлөн Удирдах зөвлөл

6.1.3. Гүйцэтгэх удирдлага

6.1.4. Ажилтан, албан хаагч, гэрээт ажилтан

## ДОЛОО: ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

7.1. “Хөдөөгийн шийдэл” ХХК-ны өмчлөгч нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байна.

7.2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, санхүүгийн тайланг санхүүгийн жил дууссанаас хойш 5 сарын дотор хэлэлцүүлнэ.

7.3. Дараах асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

7.3.1 Компанийн дүрэм болон дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах;



7.3.2 Компанийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон тусгаарлах хэлбэрээр үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах;

7.3.3 Компанийг татан буулгах;

7.3.4 Хөрөнгө оруулалт хийх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх;

7.3.5 Компанийн нийт хөрөнгийн 15 хувиас их хэмжээний болон сонирхлын зөрчил үүсч болзошгүй хэлцлийг хянаж ТУЗ-д эрхийг өгөх

7.3.6 Компанийн жилийн зорилтот түвшинг батлах;

7.3.7. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж дүгнэлт өгөх;

7.3.8 Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн жилийн ажлын тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх;

## НАЙМ: ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭРХ ҮҮРЭГ

8.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь Төлөөлөн Удирдах зөвлөл байна.

8.2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн тоо 9 байна. ТУЗ-ын даргыг гишүүдийн дотроос сонгоно. ТУЗ-ийн гишүүдийг 1 жилээр томилох бөгөөд улируулан томилж болно.

8.3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь өмчийн эрхийг хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийн баталсан удирдамжинд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ. ТУЗ нь аймгийн ИТХ-аас баталсан ТУЗ-ийн ажиллах нийтлэг журмыг баримтална.

8.4. Төлөөлөн удирдах зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.4.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлогыг тодорхойлох;

8.4.2. Компанийн бизнес төлөвлөгөө батлах;

8.4.3. Компанийн бүтэц, орон тоо, удирдлагын зардлын дээд хязгаарыг батлах;

8.4.4. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын зөвлөлийн хуралдаанд компанийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;

8.4.5. Компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

8.4.6. Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох, гүйцэтгэх удирдлагатай контракт байгуулах контрактын нөхцөл, түүнд олгох шагнал урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээг дүгнэх;

8.4.7. Төлөөлөн Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон дотоод журмыг батлах,

8.4.8 Компанийн санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг сонсох;

8.4.9. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, аймгийн ИТХ-д танилцуулж батлуулах;

8.4.10 Компаниас орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журам, хугацааг тодорхойлох;

8.4.11. Компанийн шинээр худалдаж авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх, үндсэн хөрөнгөтэй холбогдох асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

8.4.12. Хууль тогтоомжийн дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

8.4.13. ТУЗ-ын үйл ажиллагааны улирал, хагас жил, жилийн тайланг тухай бүр аймгийн ИТХ-ын зөвлөлийн хуралдаан, ИТХ-д тайлагнаж, үнэлгээ, дүгнэлт гаргуулах

### ЕС. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

9.1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурал нийт гишүүдийн олонх нь оролцсоноор хүчин төгөлдөр болно.

9.2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлаас томилно. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүргийг хүлээнэ.

9.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоол, албан бичиг, тэмдэглэл гарах бөгөөд түүнд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурж тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

9.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

9.5. Төлөөлөн Удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон гишүүн гүйцэтгэнэ.

9.6. ТУЗ-ийн хурлыг зарлах, хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүдийн хуралд оролцох, асуудлыг хэлэлцэх, хурлын дэгийг тогтоох, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

9.7. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор Төлөөлөн удирдах зөвлөл томилно.

ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх үүргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгаж болно.

9.8. ТУЗ нь үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэрийг удирдлага болгоно.

### АРАВ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

10.1. Гүйцэтгэх удирдлага нь энэхүү дүрэм болон ТУЗ-ийн даргатай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх удирдлага нь "Хөдөөгийн шийдэл" ХХК-ны гүйцэтгэх захирал байна.

10.2. Гүйцэтгэх захирлыг ТУЗ-өөс томилж, чөлөөлнө.

10.3. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ын даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, чөлөөлөх үндэслэл, үйлдвэрийн газрын санхүү, эдийн засаг, үйлдвэрлэлийн зорилтот түвшингийн үзүүлэлт, цалин, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

10.4. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

10.5. Гүйцэтгэх захирлыг чөлөөлөх асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль, Компанийн дотоод журам, контрактыг үндэслэн ТУЗ шийдвэрлэнэ.

10.6. Гүйцэтгэх захирал нь компанийн эрх бүхий албан тушаалтнуудыг томилох, чөлөөлөх тухай асуудлыг ТУЗ-тэй зөвшилцөн шийдвэрлэнэ.



10.7 Аймгийн ИТХ-ын өмнө үйлдвэрийн газрын үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жилд хоёроос доошгүй удаа үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны ажлын үр дүн, гэрээний үүргийн биелэлтийг тайлагнаж дүгнэлт гаргуулах;

10.8. Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна.

10.8.1 Дээд боловсролтой;

10.8.2 Аль нэг хуулийн этгээд буюу түүний салбар нэгжийн удирдах ажлыг 2-оос доошгүй жил хийсэн, удирдлагын зохих дадлагатай;

10.8.3 Удирдлагын ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг.

10.8.4 Гүйцэтгэх захирал төрийн, хувийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу олон нийтийн болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

10.8.5. Зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

10.8.6 Ял шийтгэлгүй байх;

10.9. Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай холбогдож үүссэн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх тохиолдолд ИТХ-ын даргаас томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгч компанийг төлөөлөн оролцоно.

10.10 Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг цаг тухайд нь гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг хариуцах;

10.11. Компанийн үйл ажиллагааны тухайн жилийн зорилтот түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж ТУЗ-д танилцуулах;

10.12. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, аймгийн ИТХ-ын, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

10.13. Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх;

10.14. Компанийн хүний нөөцийн бодлогын баримт бичиг, сул ажлын байрыг сонгон шалгаруулалтаар нөхөх журмыг тус тус боловсруулж ТУЗ-өөр хэлэлцүүлж, гүйцэтгэл үр дүнг тайлагнана.

10.15. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс баталсан орон тоо, цалингийн санд багтаан компанийн үйл ажиллагааг удирдаж зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажлаас чөлөөлөх сахилгын арга хэмжээ авах, цалин урамшууллын хэмжээг тогтоох асуудлыг холбогдох хуулийн хүрээнд шийдвэрлэх.

10.16. Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг ТУЗ-ийн хуралд хэлэлцүүлэн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар шийдвэрлүүлэх;

10.17. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах;

10.18. ТУЗ-ийн зөвшөөрлийн дагуу зарим эрх, үүргээ итгэмжлэлийн үндсэн дээр компанийн холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

10.19. Компанийн гүйцэтгэх захирал нь ажиллаж байгаа байгууллагынхаа ТУЗ-ийн гишүүн байж болохгүй. Харин бусад аж ахуйн нэгжийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж болох ба Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга байхыг хориглоно. Өрсөлдөгч аж ахуйн нэгжийн удирдлагад ажиллахыг хориглоно.

## АРВАН НЭГ: КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

11.1. ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн эрх бүхий албан тушаалтан мөн.

11.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанийн дотоод журам, ТУЗ-ийн баталсан дүрэм журамд заасан үүргийг биелүүлж, компанийн нэр хүндийг өргөх, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхийн төлөө үнэнч шударгаар ажиллана.

11.3. Компанийн ТУЗ-ийн гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага, түүний хэмжээг тогтоох асуудлыг байгуулсан гэрээ, компанийн хөдөлмөрийн дотоод журмаар тогтоох бөгөөд тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

11.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан хууль тогтоомжид зааснаар үүрэг, хариуцлага хүлээнэ.

## АРВАН ХОЁР: КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

12.1. Компанийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:

12.1.1. Өмчлөгчийн хяналт;

12.1.2. Дотоод хяналт;

12.1.3. Хөндлөнгийн аудит.

12.2. Өмчлөгчийн хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

12.3. “Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт хийх төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга батална.

12.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж аймгийн ИТХ-д танилцуулна.

12.4.1. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

12.4.2. Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;

12.4.3. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт гаргах;

12.4.4. Компанийн дүрэмд заасан болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

12.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн дүрэм, аймгийн ИТХ, Засаг даргаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган, үйл ажиллагаагаа аймгийн ИТХ-д тайлагнана.

12.6. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгахдаа энэхүү дүрэм болон холбогдох хуулиар олгогдсон эрхийг эдэлнэ.

12.7. Компанийн дотоод хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцан ажиллана.

12.8. Компанийн дотоод хяналтын ажилтан нь шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжийг гүйцэтгэх удирдлагад өгөх, ТУЗ-д танилцуулах, мэдээлэх үүрэгтэй.



12.9. Төсөв санхүү тайлангийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудитыг хөндлөнгийн аудитын байгууллагаар хийлгэнэ.

12.10. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүнг үндэслэн хөндлөнгийн аудитын компани, аудитор дараах мэдээллийг агуулсан дүгнэлт гаргана.

12.10.1. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт үнэн зөв эсэх

12.10.2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт, зохих журмын дагуу хийгдсэн эсэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг тохиолдол тус бүрээр тодорхойлох

12.10.3. Шалгалтын хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт, уг хэлцлийг хуульд заасан журмын дагуу хийсэн эсэх тухай тодорхойлолт

12.10.4 Компанийн дүрэм болон аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээгээр тодорхойлсон мэдээлэл

12.11. Хөндлөнгийн аудитын тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж дүгнэлт гарган аймгийн ИТХ-аар хэлэлцүүлнэ.

12.12. Хөндлөнгийн аудитын дүгнэлтийг аймгийн ИТХ-ын хуралдаанд хэлэлцүүлэхэд аудит хийсэн компани, аудитор тайлбар өгөх үүрэгтэй оролцоно.

12.13. Аудитын байгууллага нь өөрийн хийсэн аудитын дүгнэлтээс үүссэн хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна.

#### АРВАН ГУРАВ:ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

13.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаагүй буюу Төлөөлөн удирдах зөвлөлөөс зөвшөөрөөгүй гэрээ хэлэлцээр байгуулах, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар шийдвэрлэгдээгүй үндсэн хөрөнгийг захиран зарцуулахыг хориглоно.

13.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж эрх бүхий албан тушаалтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн компанитай хийж байгаа аливаа хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг ТУЗ-өөс зөвшөөрсөн шийдвэр, “Хөдөөгийн шийдэл” ХХК-ны дүрэм, хууль тогтоомжийн дагуу хийнэ.

13.3. “Хөдөөгийн шийдэл” ХХК нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн энэхүү дүрмийн 13.1, 13.2-т заасан хэлцлийн талаарх мэдээллийг нийтэд /байгууллага нь өөрийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан хэвлэл мэдээллийн хэрэгслээр/ мэдээлэх үүрэгтэй.

#### АРВАН ДӨРӨВ: КОМПАНИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАЙЛАН

14.1. Компани нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан аймгийн Засаг даргын зөвлөл болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нар хариуцна.

14.2. Гүйцэтгэх захирал нь ерөнхий нягтлан бодогчийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг ТУЗ-д танилцуулж зөвшилцөнө. Ерөнхий нягтлан бодогч нь мэргэжлийн нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй байна.

14.3. “Хөдөөгийн шийдэл” ХХК нь хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргуулсны дараа холбогдох хууль тогтоомжид заасны дагуу жилийн санхүүгийн тайлан, ашиг ба

алдагдлын тайлангаа аймгийн ТУЗ, Засаг дарга, ИТХ болон холбогдох хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээдэд танилцуулна.

14.4. Компанийн санхүүгийн жилийн эхлэх хугацааг тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс (эсхүл эхний жил бол байгуулагдсан өдрөөс) дуусах хугацааг мөн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр (эсхүл сүүлчийн санхүүгийн тайлант жил бол үйлдвэрийн газар нь татан буугдсан өдрийн байдлаар) тогтооно.

#### АРВАН ТАВ: КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

15.1. Компанийн санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:

15.1.1. Баланс;

15.1.2. Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;

15.1.3. Мөнгөн гүйлгээний тайлан;

15.1.4. Өмчийн өөрчлөлтийн тайлан;

15.1.5. Хуримтлагдсан ашгийн тайлан;

15.1.6. Тухайн тайлангийн хугацаанд байгуулсан сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр, төрөл, үнийн дүнгийн хамт;

15.1.7. Нэмэлт тайлбар, тодруулга;

15.1.8. Санхүүгийн тайлангийн тодруулга;

15.1.9. Хуульд заасан бусад;

15.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайланг аймгийн Засаг даргад танилцуулж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлнэ.

#### АРВАН ЗУРГАА: КОМПАНИЙН БИЧИГ БАРИМТЫГ ХАДГАЛАХ

16.1. Компани нь дараах бичиг баримтыг хадгалах үүрэгтэй:

16.1.1. Компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга, үйлдвэрийн газрыг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, улсын бүртгэлийн бүртгэлийн гэрчилгээ;

16.1.2. Аймгийн ИТХ, Засаг даргаас үйлдвэрийн газрын талаар гаргасан шийдвэр, Гүйцэтгэх удирдлагаас баталсан компанийн дотоод баримт бичиг;

16.1.3. Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг;

16.1.4. Аймгийн ИТХ, Засаг дарга болон Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, гүйцэтгэх захирлын тушаал, байгуулсан гэрээ түүний биелэлттэй холбогдох баримт бичиг;

16.1.5. Аудитын дүгнэлт;

16.1.6. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;

16.1.7. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн бичиг баримт;

16.1.8. "Хөдөөгийн шийдэл" ХХК-тай нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нэрсийн жагсаалт болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо;

16.1.9. Бусад баримт бичгүүд.

16.2. "Хөдөөгийн шийдэл" ХХК нь баримт бичгийг өөрийн үйл ажиллагаа эрхлэн явуулах газарт хадгална.

16.3. "Хөдөөгийн шийдэл" ХХК нь өөрийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлтийг байнга хадгална. Бусад баримт бичгийг 5 жилийн хугацаатайгаар хадгалах бөгөөд хугацаа дууссаны дараа архивд шилжүүлнэ.



16.4. Аймгийн ИТХ, Засаг даргаас компанитай холбоотой гаргасан шийдвэр, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр, дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлттэй холбогдол бүхий баримт бичгийг хүлээн авах, хадгалах, танилцуулах, архивт шилжүүлэх ажиллагааг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга эрхлэн гүйцэтгэнэ. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг биечлэн хариуцна.

#### АРВАН ДОЛОО: “ХӨДӨӨГИЙН ШИЙДЭЛ” ХХК-НЫ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ

17.1. Компанийн гүйцэтгэх удирдлага нь жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, аудитын дүгнэлт, нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, шилэн дансны тухай хуулиар нийтэд мэдээлэх шилэн дансны мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн самбараар олон нийтэд тухай бүр мэдээлэх үүрэгтэй.

17.2. Компанийн хүний нөөцийн мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэхээс гадна орон гарсан болон шинээр гарсан ажилтны ажлын байранд сонгон шалгаруулалт явуулахдаа дор дурдсан зарчмыг баримтална

17.2.1. Ажлын байрны зарыг 14-өөс доошгүй хоногийн хугацаанд “Хөдөөгийн шийдэл” ХХК-ны цахим хаяг, сайт болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж ил тод өрсөлдөх боломжийг нэмэгдүүлнэ

17.2.2. Ажлын байранд тавигдах ерөнхий болон тусгай шаардлага, дадлага туршлага, ур чадварын мэдээлэл, бүрдүүлэх материал, сонгон шалгаруулалт зохион байгуулах газрын хаяг байршил, хугацааны зэрэг мэдээллийг ажлын байрны сонгон шалгаруулалтын зарын мэдээлэлд багтаасан байна.

17.3. Компанийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулна.

17.4. Компанийн нууцад хамаарахаас бусад мэдээллээр олон нийтийг хангах үүрэгтэй.

#### АРВАН НАЙМ: ТАТАН БУУЛГАХ, НЭГТГЭХ НИЙЛҮҮЛЭХ

18.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу татан буулгах, нэгтгэх нийлүүлэх асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын хуралдаанаар шийдвэрлэнэ.

18.2. Татан буулгах комисс томилогдсоноор “Хөдөөгийн шийдэл” ХХК-ны гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.

#### АРВАН ЁС: БУСАД

19.1. Компанийн тухай хуульд нийцүүлэн дүрэмд тусгаснаас бусад асуудлыг хуулиар зохицуулна.

19.2 Энэхүү дүрэм болон түүнд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталж, улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болох бөгөөд үндсэн эхийг компани дээр хадгална.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_